



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/161

Улаанбаатар хот

Монгол Улсын Харилцаа холбооны
сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөнд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын даргын 2018 оны “Монгол Улсын Харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай” 2018 оны А/104 тоот тушаалаар баталсан Монгол Улсын Харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөний Хоёрдугаар бүлэг “Монгол Улсын Харилцаа холбооны дугаарлалтын багцын томъёолол”-ын хүснэгт 1-д тусгагдсан эхлэх дугаар “5” зориулалт “Нөөцөнд төлөвлөгдсөн дугаарлалт” гэж заасныг эхлэх дугаар “5” зориулалт “Үүрэн холбоо, зүйлсийн интернет, дата үйлчилгээнүүдэд” гэж өөрчилсүгэй.
2. Уг дугаарлалтын төлөвлөгөөний Гуравдугаар бүлэг “Харилцаа холбооны дугаарлалтын төлөвлөлт”-ийн 3.7 дахь хэсэгт заасан “Үүрэн холбооны үйлчилгээнд ашиглагдах дугаарлалт” гэсэн хэсэгт “Үүрэн холбооны үйлчилгээнд 9, 8 гэсэн цифрээр эхэлсэн 8 орон бүхий дугаарлалт байна. Энэхүү дугаарлалт нь газарзүйн бүсээс үл хамаарна” гэж заасныг “Үүрэн холбооны үйлчилгээнд 9, 8, 5 гэсэн цифрээр эхэлсэн 8 орон бүхий дугаарлалт байна. Энэхүү дугаарлалт нь газарзүйн бүсээс үл хамаарна” гэж өөрчилсүгэй.
3. Мөн төлөвлөгөөний Томъёолол 13-д “5х-xxxxxx” гэсэн форматыг нэмсүгэй.
4. Дээрх өөрчлөлтийг мөрдлөг болгон хэрэгжилтийг зохион байгуулахыг Харилцаа холбооны зохицуулах хороо /Г.Чинзориг/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЧИНБАТ

0004785

130



Беловерүүлсэн *Б.Заларбек*
Нийлсэн.
Хуль:
20 19 он 12 сар 6 өдөр